



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 1/11

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын 2.2, 3.2, 3.3, аймгийн Засаг даргын 2022 оны Б/07 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ж.Гантулга Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга: Ш.Эрдэнэжаргал Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: Б.Дарханбаатар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга  
Ц.Ганчимэг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Б.Мөнгөнцэцэг Архивын тасгийн дарга


С.Оюун-Эрдэнэ Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхжаргал Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Л.Цэнддорж Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, хошууч

2. Албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хянуулж, зөвшөөрөл олгуулахаар хүргүүлэхийг ажлын хэсэг (Ж.Гантулга)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030152